

БЕНА ХААН БОНОХ  
ХӨТЦҮҮН БАЖКОТЦҮЙН  
ОХУН

/УХТАР МУНАХ/

2021 он  
Улаанбаатар хот



ННА 82  
ДАА 398.2

# БЕЛА ХААН БОЛОН ХӨТӨЙН БАЙКОТЙН ОХИМ

/ҮНТЭР МҮНЭЖ/

Унгар хэлнээс монгол хэлнээ хөрвүүлсэн:  
Др.ОБРУЩАНСКИЙ БОРБАЛА АННА

Хянан тохиолдуулсан:

Чонос овогтой Баатарын ЭНХТӨР, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч  
Гэндэнжамцын ХИШИГБАДАМ, Сэтгүүл зүйн магистр,  
Философи, шашин судлалын ухааны докторант

Энэхүү бүтээлийг санаачлан, эрхлэн гаргасан Др.Обрущанский Борбала Анна-гийн зөвшөөрөлгүйгээр олшруулах, цахим хэлбэрт оруулах, хэвлэхийг хориглоно.

ISBN 978-9919-9372-5-6

Харилцах утас: 95051243, 99072224

2021 он

2

A. die Veste Gran.  
B. das Wasserfiedlein.  
C. die Ravelstadt  
D. Gochern. E. Gran flus.

GRAN.

F. Donau flus.  
G. Insel Sigeth.  
H. Thomas Berg u. Schanzen  
I. Newe Werck.  
K. Wacht Heüßer.

## ӨМНӨХ ҮГ

Элэг нэгт Монголын ахан дүүс, яруу найргийг шимтэн уншдаг уншигчиддаа зориулан XVI зууны үед зохиогдсон Унгарын нэгэн алдартай шүлгийг монгол хэлнээ хөрвүүлэн өргөн барьж байгааг минь хүлээн авна уу.

Энэхүү шүлэгт Унгарын Бела хааны ордонд зохиогдсон нэгэн тэмцээнд эцгийнхээ оронд оролцсон зоригт унгар бүсгүйн тухай өгүүлдэг. Харамсалтай нь зоригт дайчин бүсгүйн нэрийг шүлэгт тэмдэглээгүй учраас нэр нь мэдэгдэхгүй байна. Энэ шүлэгт түүх нь 1570 онд Ваг голын эрэг дээрх Сэмпте хотод зохиогдсон гэдэг бөгөөд зохиогчийнх нь нэр тодорхой биш байдаг. Гэхдээ Унгарын уран зохиолын түүхэнд шүлэгт түүхийн зохиогчийг “Semptei Anonymus” хэмээн дурддаг. Эрэлхэг, зоригтой дайчин унгар эмэгтэйчүүдийн тухай тэднийг алдаршуулсан түүх, соёлын бүтээлүүд манай ард түмний дунд маш түгээмэл байдаг.

Унгарууд эртний нүүдэлч скиф болон хүннүчүүдийг өөрсдийн өвөг дээдсээ хэмээн

үздэг бөгөөд тухайн үеийнх нь хааны ордонд бичигдсэн шаштируудад маш их мэдээлэл байдаг. Бидний өвөг дээдэс, алдарт Аттила хаан улс гүрнийхээ төвийг Унгарт төвхнүүлсэн бол түүнийг нас барснаас хойш хөвгүүд нь зүүн тийшээ нүүдэллэсэн байна. Гэвч тэд удалгүй хүчээ нэгтгэн Алмуш хаан болон түүний хүү Арпадын удирдлагын дор одоогийн Унгарын нутаг дэвсгэрт дахин суурьшсан. Дундад зууны үеийн Унгарын тэрхүү хаант улс нь Европын хамгийн хүчирхэг улсуудын нэг байсан бөгөөд тэдний газрын баялаг, гоо үзэсгэлэнгийн тухай гадаад, дотоодын олон зохиолчид тэмдэглэн үлдээсэн байдаг. Тэдгээр тэмдэглэлүүдээс үзвэл, Унгарын нутаг дэвсгэр алт, мөнгө болон давсны арвин нөөцтэй байсан бөгөөд унгар хаад түүгээрээ асар их орлого олдог байжээ. Тэрчлэн ард иргэд нь ч бас хөдөө орон нутагт мал маллаж, усан үзэм тариалж, худалдааны төв, захуудад зүүн, баруун Европын бараа бүтээгдэхүүнүүд “багширч”, бараг хүн болгон сайхан амьдардаг байв.

Унгаруудын соёл иргэншилд нүүдэлчдийн амьдралын хэв маяг, зан заншил, соёл маш их нөлөөлсөн бөгөөд одоо ч хүртэл ул мөр

A. die Veste Gran.  
B. das Wasserfeldlein.  
C. die Raizenstadt.  
D. Gochern, E. Gra...

GRAN.

F. Donau fluss.  
G. Insel Sigeth.



нь хадгалагдаж байдаг. Унгарын хаад Баруун Европын эрх баригчдаас эрс ялгаатай байв. Тэднийг Ромын эзэнт гүрний диктатор Юлий Цезарь эсвэл Трояны баатар Энейгийн удам гэдэг ч унгарын хаадын хувьд Европын хамгийн харгис хэмээгддэг “Тэнгэрийн ташуур” Атилла хааны үр удам болохыг хааны ордны шастирт тэмдэглэсэн байдаг. Энд дурдсанчлан Аттила хаан Европод хамгийн харгис, чөтгөр шуламтай адил муу нэртэй хаан байсан боловч түүний удмын унгар хаад, ард түмэн нь энэрэнгүй, ариун журамтай гэх үлгэр жишээг үзүүлэхийн тул Ромын хамба лама тэдэнд сахил хүртээжээ. Унгарын хаадаас Гэгээн Иштван түүний хүү Хунтайж Имре болон Гэгээн Ласло нар гэгээн цолыг хүртсэн байдаг. Мөн тэдний долоон гүнж нь гэгээн, гурав нь ариун цол авчээ. Энэ бол дундад зууны үеийн Европод хамгийн том үр дүн байв. Аттилагаас гаралтай Арпадын удмынхныг “гэгээн хаадын удам” хэмээн нэрлэдэг. Энэ утгаараа Хүннүгийн Аттила хааны удмынхан Өрнөдийн улс үндэстнүүдийн дунд үлгэр жишээ болжээ.

Аттилагийн удмыг Турул–шонхор шувуу буюу Арпад хааны нэрээр Арпадын удам ч гэж нэрлэдэг байв. Арпадын талын угсааны

хаад Карпатын сав газрыг 1301 он хүртэл захирч байжээ. Түүний дараагийн хоёр хаан болох Кароль Роберт (1301-1342), түүний хүү Лаёш I (1342-1382) нар нь эхийнхээ талаас Атилла, Арпад хаадтай холбоотой байв. Унгарын хаад Геза хааны үе хүртэл (972-997) шонхор шувуун сүлд бүхий Атиллагийн титмийг зүүж байсан бөгөөд хожим нь Азийн Хүннүгийн Нар, Сарны бэлгэдлийг бас хэрэглэдэг байжээ.

Унгарууд Кавказ дахь эх орондоо байхдаа Христ болон бусад шашин шүтлэгтэй “танилцсан” боловч удаан хугацаанд өвөг дээдсээсээ уламжлан ирсэн бөөгийн шүтлэгтэй байсан. Баруун Европын Христийн шашинтай харилцах харилцааг ханхүү Геза эхлүүлсэн бөгөөд 973 онд Германы санваартнуудаас авчээ. Хунтайж Гезагийн хүү Иштван шинэ итгэл үнэмшлийг төрийн шашин болгож, шашин шүтлэгийн асуудлыг өөрийн хуулиар зохицуулж байжээ.

Төв Азийн туульстай төстэй бүтээлүүд Унгаруудын дунд түгээмэл байсан бөгөөд туульсын хэв шинж нь ардын үлгэр, Гэгээн Ласло (1077-1095) болон бусад хаадын домгуудад хадгалагдан үлджээ. Унгарууд Карпатын хотгорт сууснаас хойш бараг 1200



Schanke

KA

G

A. die Veste Gran.  
B. das Wasserfiedlein.  
C. die Rosenstadt  
D. G

GRAN.

F. Donau flus.  
G. Insel Sigeth.  
Thomas Berg u. Schanzen  
wie Werck  
nicht Heilser.

жилийн турш өөр соёл иргэншил бүхий “хөрштэй” байсан ч Хүннүгийн өв уламжлалаа хадгалсаар ирсэн. XI зууны эхэн үед Гэгээн Иштван (1000-1038) хааны зарлигаар Христийн шашныг төрийн шашин болгосон боловч бөө мөргөлийн олон шинж чанарыг шинэ итгэл үнэмшилдээ уусган оруулж чадсан юм. Тэр нь одоо ч хүртэл Унгарын ёс заншилд харагддаг. Тэр үед Гэгээн Иштван хааны зарлигаар арван тосгоны дунд нэг сүм барих ёстой болж унгарууд өмнөх эх орон болох Кавказын архитектурын загвараар дугуй болон тэгш өнцөгт хэлбэртэй жижиг сүм хийдүүдийг эртний бөөгийн мөргөлийн ёслолын төвүүд дээрээ барьжээ. Ийнхүү сүм хийдүүд баригдахтай зэрэгцэн эртний шүтлэгийн шүтээн баримал, хүн чулуу зэргийг маш их нураан сүйтгэсэн байна.

XI зууны үеийн Унгарын сурвалж бичгүүдэд хэвтээ хүн чулууны тухай мэдээллүүд байдаг бөгөөд тэдгээрийг нураан устгаад өөр хэв маягаар тахилга хийж эхэлсэн байна. Түүнчлэн хааны зарлигаар худаг, булаг шандыг ч бөө мөргөлийн зан үйлээр тахихыг хориглож байсан бөгөөд хөдөөгийн Унгарууд эртний зан заншлаа хэвээр хадгалан харийн шашны өвөг дээдэс, христийн

гэгээнтнүүдэд зөвхөн залбирал үйлдэж байжээ. Тэгсэн ч Христийн шашны санваартнуудын нөлөөгөөр Унгарт Европын амьдралын хэв маяг “бий болжээ”. Тэр үед Унгарын хааны ордонд ноёдын ур чадвар, хүч чадлыг нүүдэлчдийн соёл болох бөх болон харваагаар биш харин европ маягаар жад шидэх гэх мэт “хүлэгбаатарын хэмжүүр”-ээр хэмжиж байжээ. Гэвч Унгарууд дорно дахинаас улбаатай дайчин сэтгэлгээ болон байлдааны арга тактикаа хадгалан үлдэж чадсан юм. Хааны албанд орж, харийнхныг ялж байсан хүчирхэг баатруудын тухай түүх олон байдаг ч эрэлхэг зоригт, дайчин бүсгүй хүний тухай Банко хэмээх түүх л үлдсэн бөгөөд энэхүү гайхамшигт түүхийг монголын уншигчдад толилуулах нь чухал гэж үзсэн юм.

Унгарын түүхэнд Бела хэмээх нэртэй нийт дөрвөн хаан байсан тул энэ түүх нь дээрх удирдагчийн хэнтэй холбоотой байж болохыг хэлэхэд хэцүү юм. III Бела (1172-1196) эсвэл IV Бела (1235-1270) хааны хэн нь ч байсан байж болох бөгөөд хоёулаа Аттила хааны удмаас гаралтай байв. III Бела нь 190 см орчим өндөр, том, бүргэд нүдтэй эр байсан бөгөөд Сэмтэйгийн түүхэнд дурдсан энэхүү үйл явдал түүний үед болсон байж магадгүй гэж



A. die Veste Gran.  
B. das Wasserfeldlein.  
C. die Raxenstadt.  
D. Gochern, E. Gra

GRAN.

F. Donau flus.  
G. Insel Sigeth.



олон хүн үздэг. Хэдий тийм ч Буда цайзыг Бат хааны дараа буюу 1242 онд Бела хаан барьж эхэлсэн бөгөөд XIII зууны үеэс ойр орчимд нь суурингууд бий болжээ. Түүний өмнөх III Бела хаан одоогийн Будапешт хотоос умар тийшээ Эстергом хотод өөрийн хааны ордныг байгуулжээ.

Энэхүү шүлэгт түүхнээ Унгарын хаан баатар эрсийг ордондоо урьсан боловч Хүлэгбаатар Банко хөгшин настай байсан тул тэмцээнд оролцох боломжгүй болжээ. Тиймийн учир түүний үзэсгэлэнт бага охин нь хааны баатруудтай тулалдахаар эр хүний хувцас өмсөөд очжээ. Бела хаан ордондоо ирсэн тэр залууг хөвгүүний хувцастай охин гэдгийг сэжиглэн харав. Тэгээд шалгаж үзэхээр шийдэж, баатруудтай хамт зах руу явж, зэвсгийн оронд оёдлын хэрэгсэл худалдаж авах эсэхийг нягтлав. Гэтэл эр хүний хувцас өмссөн охин зөвхөн зэр зэвсэг л сонирхож байв. Дараагийн тэмцээнд Банкогийн охин эрчүүдийг ялж, түрүүлэв. Бела хаан тэрхүү үзэсгэлэнт баатрыг эрэгтэй хүн гэдэгт итгээгүй тул дахин туршиж, бүх баатар эрсийг бассейнд оруулахыг зарлигдав. Ааваасаа сэтгэл түгшим мэдээ сонссон хөгшин Банкогийн охин нүцгэлж болохгүй тул яаралтай гэртээ харих хэрэгтэй болжээ. Бела хаан уг

шийдвэрийг дэмжиж охиныг усан онгоцонд суулгав. Охин онгоцонд суугаад хувцасныхаа товчийг тайлж, хөхөө Бела хаанд үзүүлэхүйд баатруудын дунд нэгэн охин байна гэж сэжиглэж байсныг нь нотолжээ. Хөгшин Банкогийн охин гэртээ буцан ирж, тэнд болсон үйл явдлын тухай аавтайгаа ярьж инээлдсэн гэнэ.

Энэ шүлэгт түүх нь хааны зарлигаар эцгийнхээ оронд дайнд мордож, урт хугацаанд эрэгтэй хүний хувцастай тулалдаж явсан Хуа Муланы тухай өгүүлдэг дундад зууны үеийн Хятадын яруу найрагтай төстэй хэдий ч энэ түүхийг хятадууд биш харин сяньби, табгацуудын хэлсэн дээр үндэслэсэн байж болох юм.

Энэчлэн Унгар, Хятадын яруу найрагт нүүдэлчин түмний түүхийг хойч үедээ таниулан үлдээсэн домог, түүх олон байдаг. Ер нь бол тухайн үед нөхрийнхөө эзгүйд гэр бүлийн өмч хөрөнгөө хамгаалах чадвартай байх тухайд аав нь охиддоо цэргийн сургалт явуулдаг байжээ. Нүүдэлчдийн түүхэнд эмэгтэйчүүд эрчүүдтэй ижил тэгш байр суурь эзэлдэг байсан тул буу зэвсгийг хэрэглэх, морь унах онцгой чадвартай байжээ. Баруун Европын сурвалж бичигт гэрлэсэн Унгарын гүнж

A. die Veltung Gran.  
B. das Wasserfiedlein.  
C. die Ravelstodt  
D. G

GRAN.

F. Donau flus.  
G. Insel Sigeth.  
Thomas Berg u. Schanzen  
wo Werck  
richt Heuffer.

(Скотландын Санкт Маргарет, Гэгээн Элизабет) морь унаж байсан тухай тэмдэглэсэн байдаг. Дайчин эмэгтэйчүүдийг зөвхөн дундад зууны үед ч биш эртний Грек, Ромд ч маш сонин зүйл мэт үздэг байжээ. МЭ-ийн II зууны үеийн зохиолч Страбонд Кавказийн хойд хэсэгт байх Сарматиа бол “Скиф эмэгтэйчүүдийн амазон” гэсэн домгийг бүтээжээ. Тэднийхээр дайчин эмэгтэйчүүд удирдах албан тушаалыг хашдаг бөгөөд тусдаа өөр нэгэн улсад амьдардаг байжээ.

Германчуудаас үлдсэн Нибелунгийн хоолойд эрчүүдтэй тулалдаад ялагдаж үзээгүй хүчирхэг эмэгтэй Брүхилдатай тааралддаг. Эцэст нь Зигфрид ид шидийн хүчээр л түүнийг ялж чаддаг. Энэ түүх хунтайж Геза (972-997)-ийн үед Унгарын хааны ордноос Германд орж ирсэн тул дайчин эмэгтэйчүүдийн түүх, Хүннүгийн Агтила хаантай холбоотой үйл явдлууд Германы уран зохиолд тусгагдсан байдаг. Магадгүй, энэ түүхийг тухайн үед амьдарч байсан тэмцэгч Унгар бүсгүйчүүд илүү “хүч оруулсан” байж болох юм. Геза хааны эхнэр Шаролт морь унаж, дайтаж байсан тухай тэмдэглэл ч байдаг. Шаролт гүнжийн энэ байдал нь Унгарын хааны ордонд ажилладаг Германы санваартнуудын дургүйцлийг төрүүлж, эмэгтэй хүн бол ээрэх, оёх ажилд оролцох ёстой гэж хэлжээ. Хөгшин

Банкогийн охины тухай энэхүү шүлэгт зэр зэвсэг, багаж хэрэгсэл охины сонирхлыг хэр татаж байгааг туршиж үздэг. Эмэгтэйчүүд зөвхөн гэр орныхоо ажилд анхаарах ёстой гэдэг ч түүхээс харахад Христийн шашинтай болсны дараа ч гэсэн зоригт дайчин Унгар эмэгтэйчүүдийн “тэмцлийн сүнс мөхөөгүй” юм шиг санагддаг. Зоригт дайчин эмэгтэйчүүд ялангуяа Осман-Туркийн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэлд оролцож байсан бөгөөд тэдний талаар Шандор Такачын “Хуучин Унгарын эмээ нар” номонд хураангуйлан бичжээ.

Монгол бөхийн зодог шуудгийн гарал үүслийн тухай домог ч бас хүчирхэг эмэгтэйчүүдтэй холбоотой байдаг тул Монголд ч зоригт дайчин эмэгтэйчүүд нэлээд байжээ гэж үзэж болохоор байдаг. Монголын түүхэн дэх дайчин эмэгтэйчүүдийн талаар бид хангалттай уншдаг. Хамгийн алдар цуутай эмэгтэй бол Өэлүн үжин мөн. Өэлүн үжин нөхрөө нас барсны дараа бүх хүчээ дайчлан монгол хаадыг нэгтгэж, дараа нь хүүгээ хаан болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Энэ мэтчлэн Монголын түүхэн дэх олон хатад ийм амьдралаар амьдарсан. Тэдний тухай Монголын эрдэмтэн, профессор Ж.Урангуа, Д.Энхцэцэг нар ном бичсэн байдаг.



## СЕМПТЭЙ НЭРГҮЙ

### БЕЛА ХААН БОЛОН ХӨГШИН БАНКОГИЙН ОХИН

Эртний тууль хайлж байна би, та сонсогтун!  
Эрэлхэг Бела хааны тухай ярьж байна.  
Эртний хөгшин Банкогийн тухай  
Элэр дурсамжийг хүүрнэж байна би, та  
сонсогтун!

Бела хааны зарлигийг тунхаглахаар  
Бүхий л нутгийн удирдагч, засаглагчид  
Нэгэн зуун далан долоон шилдэг баатар эрсийг  
Нэгдэж ордондоо цуглуулахаар зарлав.

Өргөл тушаалыг хөгшин Банко сонсоод  
Өндөр настай болсон би, ордон явахад хэцүү  
байна гэв.  
Гал үргүй тэрээр шаналж  
Гагцхүү хэнийг хааны ордонд илгээхээ боджээ.

Ерөөлөөр төрсөн есөн охинтой билээ.  
Ер бусын үзэсгэлэнтэй нь хамгийн отгон нь  
байлаа.  
Эр хүн болоод би явъя хэмээн эрс шийдэмгээр  
Эцэгтээ мөргөж, охин хэллээ.

“Өр зүрхний хайртай аавынхаа төлөө  
Үсээ тайруулан, хуяг өмсөөд явна, би  
Эрэмгий сайн аргамгаа надад өгөөрэй  
Эрэлхэг хүү шиг очно, би

Алдар хүндээр чинь овоглож, Буда ууланд  
Аав таныхаа төлөө хааны ордонд очиж  
Агуу шударгыг харуулж  
Айлтгүй би тэнд байх болно” гэлээ.

Хайртай охиныхоо үгэнд итгэсэн эцэг нь  
Хааны ордон руу мордуулж үлдлээ, үрээ  
Хүлэг баатрын төрхтэй түүнийг ордонд ирэхэд  
Хаан Бела уулзаад шууд хэллээ гэнэ, түүнд

“Тайхамшигтай залуу баатар вэ?  
Ганган охин шиг харагдана.  
Эр хүн шиг алхах чинь  
Эргэлзээ төрүүлж байнам, надад

Хэний үр, хаанаас ирсэн бэ?  
Хэрэг зоригоо батлан үзүүл!  
Хэрвээ чи охин байсан бол

Хэрхэвч Буда хотноо илүү үнэлэгдэх болно” гэлээ.

Дээд ноёддоо хаан зарлигдаж:

Далан долоогоос тавин нэгэн баатар эр  
Буда хотын зах руу удахгүй гарах болно.  
Бүгдээрээ зүү, утсан бөмбөрцөг зэргийг  
худалдаж аваарай хэмээвэй.

“Залуу хүлэг баатар хэрвээ бүсгүй бол  
Зүү, утсан бөмбөрцөг сонирхох болно.  
Гэрэлт зоригтой залуу баатар бол  
Гялалзах зэвсгийг сонгох болно” хэмээн  
бодвой.

Далан долоогоос тавин нэгэн баатрууд  
Буда хотын захаар зугаацав.  
Даруухан залуу зүү, утсан бөмбөрцгийг харсан  
ч үгүй, харин  
Бугын эвэр нум шинжиж, балт зэвсэг сонирхов.

Эвэр нумандаа уртхан сум сонгон  
Эрчлэн сойж, хоёр хуруугаараа татаад  
“Алив нааш ир, бүгдээрээ харвая” гэж  
Агсаргат баатруудыг дуудан уриалжээ.

Сүрлэг баатрууд нумаа татахад  
Шившсэн сум нь байндаа туссангүй.  
Сүүлд нь харвасан Банкогийн хөвүүний сум  
Сүвэгчээр тусан байндаа онов оо.

Уухайлан дэмжсэн баатрууд түүнийг  
Улам хөгжөөн бахархан магтав.  
“Чулуу хэн хол шидэхээ үзье” гэж  
Чухамдаа бүгд зөвшилдөн шийдэв.

Далан долоон баатар, тавин нэгэн нөхөд  
Давуулж хэн нь хол шидэхээ үзлээ.  
Дахиад л Банкогийн хөвүүний далласан чулуу  
Тохой холоор бусдаасаа түрүүлээ.

Эрэлхэг эрчүүдийн цөс хөөрч  
Эрэмгий хурднаа шалгахаар шийдэв.  
Нумнаас тавьсан сум шиг хурдалж,  
Нөгөө Банкогийн хөвүүн ахиад л магнайлав.

Гурван даалгаварт ялагдсан эрчүүд  
Гуниггүй сайхан ууцгаая гэв.  
“Хааныхаа төлөө хундага тулгая” гээд  
Хөгшин Банкогийн хөвүүнийг дундаа суулгав аа.





Бакхус бурхандаа тахил өргөж  
Балтай шимт дарсыг хүртэн наргив.  
Банкогийн хөвүүн огт согтолгүй  
Бахархалтай сайхан дуулж, ая хөгжөөв.

Сүрлэг баатрууд өглөө эртлэн  
Суут хаандаа очиж хэлэв:  
Залуу баатар бүсгүй биш, эр биш  
Зайлбаргүй тэр шулам байх аа

Сумаар харваад бид ялагдав, хаантан минь  
Чулуугаар шидээд бид дарагдав, хаантан минь  
Шандсаа сорьж гүйгээд бид хоцров, хаантан  
минь  
Шавхсан тэмцээнд Банкогийн баатар биднийг  
ялсан шүү, хаантан минь хэмээв.

Баатруудынхаа ярианд гайхсан хаан  
Баахан бодлогоширч суув гэнэ.  
Усан санд бүгдээрээ сэлье гэж  
Ухаан сийлж Бела хаан хэлэв ээ.

Хаантан бас усан санд ороход  
Харин Банкогийн хөвүүн тэнд байсангүй.  
Хөгшин Банкогийн хөвүүн яагаад орсонгүй вэ?  
Хүрч ир хэмээн хаантан тушаав.

Бидэнтэй хамт усан санд ор гэж  
Би чамд тушаасан байх аа  
Хөгшин Банкогийн хөвүүн чи  
Хаан миний зарлигийг яагаад зөрчив  
хэмээхүйд,

Гайхах хэрэггүй, хаантан минь  
Гартаа барьсан захидлыг минь харна уу  
Гамшигт мэдээг дуулгаж  
Гашуун сэтгэлээр бичсэн байна.

Харгис Түрэг, Татарууд  
Хамаг цайзыг минь шатаан дээрэмджээ.  
Хайрлах өрөвдөх сэтгэлгүй тэд  
Харгисаар түмнийг минь зовоожээ гэлээ.

Улай дуудсан мэдээг сонсоод хаан  
Усан сангаас ухасхийн гарав.  
Баатрууд жанждаа жагсаан журамлаад  
Банкогийн хөвүүнд ийнхүү хэлэв:

Яарагтун хүү минь, гэртээ харь  
Явдал замдаа бүү саатаарай.  
Үзэсгэлэнт нутгаа өмгөөлж тэмц!  
Өнөр түмнээ үтэр аврагтун!



Эцэг чинь хөгширч доройтсон учир  
Эр хүний ёсоор чи хамгаалагтун!  
Эрэлхэг зоригоо нотлон тулалдагтун!  
Эрэмгий баатар минь даруй мордогтун гэв ээ.

Бела хааныхаа зарлигийг даган  
Банкогийн охин тулаанд мордохоор  
Бэлэн болсон дайчин эрстэйгээ  
Буда уулаа орхин явлаа.

Дунай мөрөн дэх онгоцондоо  
Дуртай “комока” хүрмээ тайлав.  
Хоёр алимаа гаргаж үзүүлээд  
Хаан эзэндээ ийнхүү хэлэв ээ:

Хаантан минь, хаантан минь  
Хараат улсад чинь ийм алим бий юу?  
Үнэтэй ийм алимыг минь  
Үзсэнгүй юу? Та харав уу?

Бела хааны Буда хотод  
Би энэ алимаа авчирсан шүү.  
Харин хаантан та минь  
Хазаж амжилгүй явуулчих вуу гэлээ.

Учрыг ухаарсан Бела хаан  
Уулга алдан тушаал буулгав.  
Бүүр явчихаас нь өмнө амжиж  
Бүгдээрээ түүнийг барьж ир гэв ээ.

Хүчит хөлгөөр араас нь нэхээрэй  
Хүргэж заавал надад авчир гэж хэлэв ээ.  
Чи бол миний мөнхийн эхнэр болой  
Чинхүү ганц хатан минь юм гэв ээ.

Дунай мөрнийхөө урсгалаар аялсаар  
Дарвуулт онгоц нутагтаа ирэв ээ.  
Хуй салхи эрчлэх адил хөвсөөр  
Хөгшин аавдаа яаран ирэв ээ.

Эр зоригт охин нь  
Эрхэмсэг хаандаа айлчилсан тухайгаа  
Эцэгтээ ярихад ихэд хөхрөв.  
Энхрий охиноо үлэмж хайрлав.

Нэгэн мянган таван зуун далан оны  
Нэн олон жилийн өмнөх явдлыг  
Одоо би хүүрнэж байнам.  
Охин тэнгэр сарын эхэн долоо хоногт  
Орчих дээд тэнгэрт магтан дуулсаар ирвэй.



9 789919 937256

